



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/21

Маңдалговь

Барилга, байгууламжийг ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралт, аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/406 дугаар "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссыг байгуулах тухай" захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын гадна пасадны ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Э.Энхмэнд	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга:	Б.Буманбаатар	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)
Гишүүд:	Э.Цэрэннадмид	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын хяналтын улсын байцаагч)
	И.Эрдэнэцог	(Сайнцагаан сумын Засаг даргын орлогч)
	Н.Золбоо	(Зураг төсөл зохиогч "Скэч" ХХК-ийн ерөнхий инженер)
	Х.Анхбаяр	(Гүйцэтгэгч "Хангда" ХХК-ийн менежер)
	Т.Уранбайгаль	(Засаг даргын Тамгын газрын архивын тасгийн дарга)

2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс хууль, дүрмийн дагуу ажиллаж, барилгын норм ба дүрэм, зураг төсөлд нийцүүлэн дүгнэлт гарган, танилцуулахыг комисс (Э.Энхмэнд)-т даалгасугай

ДАРГА

Э.ЧАГНААДОРЖ



D/ Alban bichig/ Tushaal 2024.06.13

4824010091